

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“ХОВД АЗЗА” ТӨХК-ИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН

Аудитын код: ХОА-2021/02/СТА-ТӨҮГ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2021 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар  
Утас: 70433061

Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Мөнхтулга

Утас: 70432545

цахим хаяг: munkhtulga.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
4 .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний тайлан .....	7
3.Аудитын тайлан.....	8
3.1. Ерөнхий зүйл.....	8
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	9
3.4. Материаллаг байдал .....	9
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	9
3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	11
3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа .....	12
3.8. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.10. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа.....	13
3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	13
4. Менежментийн захидал .....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	13

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
84000 Цамбалсрав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 675-70433081, Факс: 675-70433081  
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД АЗЗА ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН  
ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.БАТСҮХ ТАНАА

2021.03.15 № 4/163  
тантай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Ховд АЗЗА” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Ховд АЗЗА” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, авто зам арчлалтын чанар зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЯДБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Үзүүлэлтийн нэр	/төгрөгөөр/	
	Үлдэгдэл	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1.ХӨРӨНГӨ</b>	0.00	<b>0.00</b>
<b>1.1.Эргэлтийн хөрөнгө</b>	0.00	<b>0.00</b>
1.1.1.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	166,848,953.60	468,227,696.10
1.1.2. Дансны авлага	156,110,428.79	50,788,869.17
1.1.3. Татвар НДШ-ийн авлага	4,500,610.82	5,360,741.15
1.1.4. Бусад авлага	6,145,456.31	12,803,378.05
1.1.6.Бара материал	153,306,648.98	135,209,404.66
1.1.9. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	0.00	36,500,000.00
<b>1.1.11. Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>486,912,098.50</b>	<b>708,890,089.13</b>
1.2.1 Үндсэн хөрөнгө	1,909,107,888.65	1,689,994,501.05
1.2.2 Биет бус хөрөнгө	227,764,000.00	227,524,000.00
<b>1.2.12 Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>2,136,871,888.65</b>	<b>1,917,518,501.05</b>
<b>1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,623,783,987.15</b>	<b>2,626,408,590.18</b>
<b>2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	0.00	<b>0.00</b>
<b>2.1 Өр төлбөр</b>	0.00	<b>0.00</b>
<b>2.1.1 Богино хугацаат өр төлбөр</b>	0.00	<b>0.00</b>
2.1.1.1 Дансны өглөг	1,910,043.08	0.00
2.1.1.3 Татварын өр	411,474.69	267,661.69
2.1.1.8 Урьдчилж орсон орлого	388,774,699.38	328,208,870.38
<b>2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>391,096,217.15</b>	<b>328,476,532.07</b>
2.1.2.4 Бусад урт хугацаат өр төлбөр	385,901,585.00	385,901,585.00
<b>2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>385,901,585.00</b>	<b>385,901,585.00</b>
<b>2.2 Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>776,997,802.15</b>	<b>714,378,117.07</b>
2.3 Эздийн өмч	78,052,800.00	78,052,800.00
2.3.1 Төрийн	78,052,800.00	78,052,800.00
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	83,947,398.45	81,102,698.45
2.3.8 Эздийн өмчийн бусад хэсэг	1,591,659,543.06	1,585,552,939.76
2.3.9 Хуримтлагдсан ашиг	93,126,443.49	167,322,034.90
2.3.11 Эздийн өмчийн дүн	<b>1,846,786,185.00</b>	<b>1,912,030,473.11</b>
<b>2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,623,783,987.15</b>	<b>2,626,408,590.18</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Үзүүлэлтийн нэр	/төгрөгөөр/	
	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
<b>1. Борлуулалтын орлого(Цэвэр орлого)</b>	<b>1,035,723,964.91</b>	<b>1,342,888,114.94</b>
2.Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	879,842,829.58	1,095,954,799.91
<b>3. Нийт ашиг (алдагдал)</b>	<b>155,881,135.33</b>	<b>246,933,315.03</b>
5. Хүүний орлого	7,250,838.58	9,716,117.40
8. Бусад орлого	63,232,183.28	50,059,844.55
10. Ерөнхий ба удирдлагын зардал	175,547,067.83	211,663,736.49
12. Бусад зардал	36,521,008.86	20,465,769.75
14. Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		7,959,090.91
<b>18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>14,296,080.50</b>	<b>82,538,861.65</b>
19. Орлогын татварын зардал	3,684,789.18	9,597,970.24
<b>20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>10,611,291.32</b>	<b>72,940,891.41</b>

21. Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагд)		0.00
22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	10,611,291.32	72,940,891.41
24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	10,611,291.32	72,940,891.41

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	78,052,8 00.00	86,109,9 98.45	1,591,659,5 43.06	81,912,6 31.17	1,837,734,972.68
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3	Залруулсан үлдэгдэл					
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				10,611,2 91.32	10,611,291.32
5	Бусад дэлгэрэнгүй орлого					
6	Өмчид гарсан өөрчлөлт					-
7	Зарласан ногдол ашиг				(1,560,079.00)	(1,560,079.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(2,162,600.00)		2,162,600.00	-
1	2020 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	78,052,8 00.00	83,947,3 98.45	1,591,659,5 43.06	93,126,4 43.49	1,846,786,1 85.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				0	
3	Залруулсан үлдэгдэл					
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				72,940,8 91.41	72,940,8 91.41
5	Бусад дэлгэрэнгүй орлого					
6	Өмчид гарсан өөрчлөлт		-	(6,106,603.30)	-	(6,106,603.30)
7	Зарласан ногдол ашиг				(1,590,000.00)	(1,590,000.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдэлийн хэрэгжсэн дүн		(2,844,700.00)		2,844,700.00	-
9	2020 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	78,052,8 00.00	81,102,6 98.45	1,585,552,9 39.76	167,322,0 34.90	1,912,030,4 73.11

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
<b>1.1 Мөнгөн орлогын дүн</b>	<b>1,071,249,881.65</b>	<b>1,558,663,082.35</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,052,042,236.65	1,499,979,805.35
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		550,000.00
Бусад мөнгөн орлого	19,207,645.0	58,133,277.00
<b>1.2 Мөнгөн зарлагын дүн</b>	<b>989,698,815.80</b>	<b>1,205,950,657.25</b>
Ажиллагчдад төлсөн	217,871,444.00	265,717,644.00
Нийгмийн даатгалын байгуулгаад төлсөн	87,375,168.00	103,908,309.00
Бараа материал худалдан авахад төлсөн	193,679,884.09	296,090,131.64
Ашиглалтын зардал төлсөн	5,145,317.31	5,741,529.90
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	200,289,418.27	198,244,490.18

Татварын байгуулгад төлсөн	118,217,541.05	151,217,374.77
Даатгалын төлбөрт төлсөн	3,400,260.00	3,800,000.00
Бусад мөнгөн зарлага	163,719,783.08	181,231,177.76
<b>1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>81,551,065.85</b>	<b>352,712,425.10</b>
<b>Мөнгөн орлогын дүн</b>	-	<b>8,755,000.00</b>
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	8,755,000.00
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>70,169,800.00</b>	<b>68,214,800.00</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	70,169,800.00	68,214,800.00
<b>2.20 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(70,169,800.00)</b>	<b>(59,459,800.00)</b>
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>7,250,838.58</b>	<b>9,716,117.40</b>
Хүү ба урамшуулалын орлого	7,250,838.58	9,716,117.40
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>1,560,079.00</b>	<b>1,590,000.00</b>
Төлсөн ногдол ашиг	1,560,079.00	1,590,000.00
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>5,690,759.58</b>	<b>8,126,117.40</b>
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	17,072,025.43	301,378,742.50
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	<b>149,776,928.17</b>	<b>166,848,953.60</b>
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>166,848,953.60</b>	<b>468,227,696.10</b>

## 2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Д.д	Үндсэн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 он		Харьцуулалт	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувиар (2020гүй/2020төл)	Дүнгээр (2020гүй-2020төл)
1	Нийт орлого	мян.төг	1,106,206.9	1,311,858.3	1,410,623.1	107.5	98,764.8
	Үүнээс: Улсын чанартай ЗЗА	мян.төг	774,955.5	996,030.1	965,019.2	96.9	(31,010.9)
	Бусад	мян.төг	331,251.4	315,828.2	445,603.9	141.1	129,775.7
2	Нийт зардал	мян.төг	1,091,910.9	1,299,917.3	1,328,084.3	102.2	28,167.0
	Үйл ажиллагааны зардалд	мян.төг	175,547.1	233,982.6	211,663.7	90.5	(22,318.9)
3	Татварын өмнөх ашиг	мян.төг	14,296.0	11,941.0	82,538.8	691.2	70,597.8
4	Цэвэр ашиг/ алдагдал/	мян.төг	10,611.2	10,746.9	72,940.9	678.7	62,194.0
5	Төсвийн төлбөрт	мян.төг	203,191.5	238,214.8	255,437.0	107.2	17,222.2
	а/Орлогын татварт	мян.төг	3,684.8	1,194.1	9,597.9	803.8	8,403.8
	б/НӨАТ	мян.төг	78,457.9	77,861.6	107,354.4	137.9	29,492.8
	в/НДШ	мян.төг	87,214.5	118,607.4	102,817.5	86.7	(15,789.9)
	г/ХАОТатварт	мян.төг	28,065.9	32,661.6	29,680.3	90.9	(2,981.3)
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татварт	мян.төг	1,473.2	1,500.0	1,473.2	98.2	(26.8)
	е/Тээврийн хэрэгслийн татварт	мян.төг	1,798.3	1,935.5	1,159.5	59.9	(776.0)

	ж/Бусад татварт	мян.төг	2,496.9	4,454.6	3,354.2	75.3	(1,100.4)
6	Төрийн өмчийн ноогдол ашиг	мян.төг	1,560.1	1,705.5	10,941.1	641.5	9,235.6
7	Нийт авлага	мян.төг	166,756.5	105,124.4	68,952.9	65.6	(36,171.5)
8	Нийт өглөг	мян.төг	776,997.8	525,016.4	714,378.1	136.1	189,361.7
	Үүнээс: 8.1 богино хугацаат	мян.төг	391,096.2	139,114.8	328,476.5	236.1	189,361.7
	8.1.а. Урдчилж төлөгдсөн орлого	мян.төг	388,774.7	137,025.5	328,208.9	239.5	191,183.4
	8.1.б Дансны өглөг /бусад/	мян.төг	2,321.5	2,089.3	267.6	12.8	(1,821.7)
	8.2 Урт хугацаат өр төлбөр		385,901.6	385,901.6	385,901.6	100.0	-
9	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	төг	0.987	0.991	0.941	95.0	(0.05)
10	Хөрөнгө оруулалт	мян.төг	70,169.8	71,500.0	68,214.8	95.4	(3,285.2)
11	Ажиллагсдын тоо	хүн	38	48	38	79.2	(10.0)
12	Цалингийн сан		336,808.3	423,597.7	399,979.3	94.4	(23,618.4)
13	Нэг ажилтаны дундаж цалин	мян.төг	691.50	698.69	831.90	119.1	133.2

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Ховд АЗЗА” ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг гүйцэтгэх захирал Б.Батсүх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 10-наас 2020 оны 03 дугаар сарын 15–ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Мөнхтулга хариуцаж хэрэгжүүлэв.

Ховд “АЗЗА” ТӨХК нь 2020 оны санхүүгийн тайлангаа Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 23 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд хувьцаат компани гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр, үүнээс Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 100 хувь эзэмшиж байна.

“Ховд АЗЗА” ТӨХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Улсын чанартай зам засвар, арчлалт
- Улсын чанартай замын бэлэн байдлыг хангах
- Зам засвар, арчлалт, барилга угсралт

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт*
- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

“Ховд АЗЗА” ТӨХК нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас дотоод аудит, хяналт шалгалт хийгдээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 226.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 314.7 сая төгрөгөөс 1 хувиар тооцож 3.1 сая төгрөгөөр тогтоолоо.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Ховд АЗЗА” 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2.64 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	166.85	468.23	301.38	181%
Авллага	166.75	68.95	-97.80	-59%

Бараа материал	153.30	135.21	-18.09	-12%
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		36.50	36.50	100%
Үндсэн хөрөнгө	2,136.87	1,917.52	-219.35	-10%
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,623.77</b>	<b>2,626.41</b>	<b>2.64</b>	<b>0%</b>
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>391.09</b>	<b>328.48</b>	<b>-62.61</b>	<b>-16%</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>385.9</b>	<b>385.90</b>		
Цэвэр хөрөнгө, өмч	1,846.78	1,912.03	65.25	4%
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,623.77</b>	<b>2,626.41</b>	<b>2.64</b>	<b>0%</b>

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүнд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 468.23 сая төгрөг болж 301.38 сая төгрөгөөр өссөн нь ашигт ажиллагаа өсөж, авлага бууруулж, төлбөрийн чадвар өссөнөөс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 68.95 сая төгрөг болж 97.8 сая төгрөгөөр буурсан нь 2019 онд үүссэн Ховд аймгийн Мөнххайрхан сумын Сэнхэрийн голын 31.29 у.м модон гүүрний засварын ажлын санхүүжилтийн авлага 27.5 сая төгрөг, бусад харилцагч байгууллагуудаас 70.3 сая төгрөгийн авлагыг барагдуулж, өмнөх үеийн авлагыг 59 хувиар бууруулж ажилласнаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2020 онд үүссэн 41,21 сая төгрөг, 1-2 жилийн насжилттай 3.15 сая төгрөг, 3-с дээш жилийн насжилттай 24.59 сая төгрөгийн нийт 68.95 сая.төгрөгийн авлага байгаагаас албан байгууллага, хувь хүнээс авах авлага 73.6 хувь, ажилтан албан хаагчдаас авах авлага 18.6 хувь, татвар, нийгмийн даатгалын авлага 7.8 хувийг тус тус эзэлж байна.

Нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 135,21 сая төгрөг болж 18,09 сая төгрөгөөр буурсан нь бараа материалын зарцуулалтаас шалтгаалжээ.

Тайлант онд худалдан авалтаар 454.93 сая төгрөгийн бараа материал худалдан авч үйл ажиллагаандаа 473.02 сая төгрөгийн бараа материал зарцуулжээ.

Бараа материалын дансны үлдэгдэлд байгаа хөрөнгөөс цаашид ашиглагдахгүй хөрөнгө байхгүй байна.

Оны эцэст 135.2 сая төгрөгийн бараа материалын нөөцтэй байгаа нь зам засвар арчлалтын ажилд шаардагдах 69.85 сая.төгрөгийн үнэ бүхий үндсэн материал, 10.76 сая төгрөгийн үнэ бүхий машин механизмын тослох материал, 29.29 сая төгрөгийн үнэ бүхий сэлбэг хэрэгсэл, 25.3 сая төгрөгийн үнэ бүхий аж ахуй хангамжийн болон бусад материал байна.

Тайлант онд авлагаас 35.9 сая төгрөгийн Ковш авч борлуулах зорилгоор эзэмшиж байгаа эргэлтийн бус хөрөнгөд тайлагнажээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1917.52 сая төгрөг болж 219.35 сая төгрөгөөр буурсан нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 67.17 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зохих шийдвэрийн дагуу 66.88 сая төгрөгийн анхны өртөгтэй САТ 438 маркийн экскаваторыг Улаангом дулааны 2-р станц ТӨХК-д балансаас балансад шилжүүлсэн, зохих шийдвэрийн дагуу 189.73 сая төгрөгийн анхны өртөг бүхий ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө нөхсөн цаашид сэргээн засварлах боломжгүй болсон машин механизмуудыг ашиглалтаас хасаж, дуудлага худалдаагаар борлуулж тайлант оны элэгдлийн зардал 280.4 сая төгрөг болсноос шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгөөс Улаангом дулааны 2-р станц ТӨХК-д 66.88 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлсэн байна.

Биет бус хөрөнгө үлдэгдэл өртгөөр 227,52 сая төгрөг болж 0.24 сая төгрөгөөр буурсан нь тайлант жилд байгуулсан программ хангамжийн элэгдлийн дүнгээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 714.38 сая төгрөг болж 62.61 сая төгрөгөөр буурсан нь өмнөх тайлангаар гарсан дансны өглөг болон татварын өрийг бүрэн барагдуулсан , урьдчилж орсон орлого 60.56 сая.төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр 385.9 төгрөгийн өртэй байгаа нь 2009 онд тус компанид Кувейтийн сангийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн 12 нэрийн машин механизм, тоног төхөөрөмжийг бусад урт хугацаат өр төлбөрөөр бүртгэн тайлагнаснаас хойш бүртгэлд өөрчлөлт ороогүй байна.

Бусад 328.47 сая төгрөгийн өр татварын тооцоолол, баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх төсөл хөтөлбөрийн хүрээнд үнэ төлбөргүй нийлүүлэгдсэн авто замын машин механизмыг орлогын аргаар урьдчилж орсон орлого дансанд бүртгэснээс шалтгаалж үүссэн байна. Энэ нь 328.21 сая.төгрөгийг урьдчилж орсон орлого, 0.267 нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын өр болно. Эдгээр өр төлбөр нь компанийн төлбөрийн чадварт нөлөөлөх зүйлгүй болно.

Эздийн өмч дансны үлдэгдэл 1912.03 сая төгрөг болж 65.25 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн ашиг нэмэгдсэнээс. шалтгаалжээ. Үүнд:

- Төрийн өмчийн дансны үлдэгдэл 78.05 сая төгрөг байгаа бөгөөд бүртгэлд өөрчлөлт ороогүй байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 81.10 сая төгрөг болж 2,84 сая төгрөгөөр буурсан нь ашиглалтаас хасагдсан хөрөнгийн дахин үнэлгээний хэрэгжилтийн дүнгээс шалтгаалжээ.

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэл 1585.55 сая төгрөг болж 6.1 сая төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2019.12.16-ны өдрийн 565 тоот тогтоолын дагуу Улаангом дулааны хоёрдугаар станц ТӨХК-д хөрөнгө шилжүүлснээс шалтгаалжээ.

Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг 94.38 сая төгрөг болж 1.25 сая төгрөгөөр өссөн нь дахин үнэлгээний хэрэгжсэн дүн 2.84 төгрөг, төрийн өмчид төлсөн ноогдол ашиг 1.59 төгрөг байгаа нь шалтгаалжээ.

### **3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Ховд АЗЗА ХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар 597 дүгээр тогтоолоор “Ховд АЗЗА” ТӨХК-ийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1311.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 1299.9 сая төгрөгөөр, цэвэр ашгийг 10.74 сая төгрөгөөр тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын 5 арга хэмжээнд 71.5 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1410.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1328.08 сая төгрөгийн зардал гарган, 72.94 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь борлуулалтын орлого 1342.9 сая.төгрөг, 67.7 сая.төгрөг бусад орлогоос бүрджээ. Нийт орлогын 68.4 хувийг Ховд–Булган Улсын хил чиглэлд-117,4 км, Ховд-Говь-Алтай чиглэлд–261,4 км, Ховд- Улаангом чиглэлд-100 км, Ховд–Завхан чиглэлд 158 км, Ховд–Баян–Өлгий чиглэлд–112,56 км, нийт 749,36 км улсын чанартай замд хийсэн засвар арчлалтын ажлаар,

31.6 хувийг Ховд аймгийн Мөнххайрхан сумын Хөндийн амны 25.1 у.м модон гүүрний ,Хар давын 25.1 у.м модон гүүрний барилгын ажил, Ховд аймгийн төвийн авто замыг нөхөх, уулзварын эргэлтийг өргөтгөх, Жаргалант сумын сургууль, цэцэрлэгүүдийн орчимд хурд сааруулагч хийх, Мянгад сумын Цагаан булан багт хийсэн зам засварын ажил , бусад байгууллага, харилцагчидтай байгуулсан гэрээт ажлын болон бусад орлогоор тус тус гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 1. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>1</b>	<b>Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт</b>						
<b>2</b>	<b>Нийт орлого</b>	<b>сая.төг</b>	<b>1106.21</b>	<b>1311.86</b>	<b>1410,62</b>	<b>98,76</b>	<b>107.5</b>
	Үүнээс: Цэвэр борлуулалт	сая.төг	1106.21	1311,86	1410,62	98.76	107.5
<b>3</b>	<b>Нийт зардал</b>	<b>сая.төг</b>	<b>1091.91</b>	<b>1299.92</b>	<b>1328,08</b>	<b>28.16</b>	<b>102.2</b>
	Үүнээс:	сая.төг	879.84	1031.43	1095,95	64.52	106.3
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг						
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	сая.төг	175.54	233.98	211,66	-22,32	90.5
	в) Хөрөнгө оруулалт их засвар						
<b>4</b>	<b>Цэвэр ашиг, алдагдал</b>	<b>сая.төг</b>	<b>10.61</b>	<b>10.75</b>	<b>72,94</b>	<b>62.19</b>	<b>678,7</b>

Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтүүдийн биелэлт, гүйцэтгэлийн шалтгаан нөхцөлийг үзүүлэлт бүрээр танилцуулбал:

Нийт орлогын гүйцэтгэл 1410.62 сая төгрөг болж төлөвлөснөөс 98.76 сая төгрөг буюу 7.5 хувиар давж биелсэн нь орон нутагт модон гүүр барих, орон нутгийн зам засварын арчлалт гүйцэтгэх тендерт шалгарч ажил гүйцэтгэсэн болон бусад орлогын төлөвлөгөөг 129.77 сая. төгрөг буюу 41.1 хувиар давуулан биелүүлсэн зэрэг шалтгаанаас голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1328.08 сая төгрөг болж, төлөвлөснөөс 28.16 сая төгрөг буюу 2.2 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээ төлөвлөсөн үзүүлэлтээс өссөн нь гол нөлөө үзүүлсэн байна. Тайлант онд цэвэр ашиг 72.94 сая төгрөг болж, төлөвлөснөөс 62.19 сая төгрөгөөр илүү байгаа нь нийт орлого 7.5 хувиар давж биелсэн, ашигт ажиллагааны түвшин нэмэгдэж, борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал 0.94 төгрөг болж, 5 хувиар буурсан зэргээс тус тус шалтгаалж байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн №315 тоот шийдвэрийн дагуу тайлант онд 1.59 сая төгрөгийн ногдол ашиг буюу ашгийн 15 хувийг төвлөрүүлэхээс 1.59 сая төгрөгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт бүрэн төвлөрүүлжээ.

### 3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Зам тээврийн хөгжлийн яам, Хувьцаа эзэмшигчдийн төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч 6, хараат бус 3, нийт 9 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж

байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2020 онд 4 удаа зохион байгуулж 5 асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

2020 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд нийт 26.32 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 24.68 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: Цалин, урамшууллын зардалд 20.61 сая, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 2.9 сая, бусад зардалд 1.16 сая төгрөгийн зардлыг тус тус санхүүжүүлсэн байна.

### **3.8. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 169 мэдээллээс 168 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### **3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

### **3.10. Аудитын илрүүлэлт**

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

#### **Залруулсан алдаа**

Аудитаар залруулсан алдаа байхгүй болно.

#### **Төлбөрийн акт, албан шаардлага**

Аудитаар төлбөрийн акт, албан шаардлага бичигдээгүй.

### **3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татах асуудал байхгүй байна.

## **4. Менежментийн захидал**

---

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## **5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

---

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

## **ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**